

Яагаад гэвэл урьд өмнө явсан удаа дараагийн улс төрийн кампаний шарх, сорви эдгээгүй, хүмүүсийн айх явдал бүрэн арилаагүй байна. Цаашид хэрхэхийг өнөөгийн улс төрийн бодлоготнууд харуулах болохоор ард түмэн түүнийг л хүлээж, ажиглаж явна даа гэж санагдлаа.

**МОНГОЛД БАЙГАА МАНЖ
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ
УРЬДЧИЛСАН СУДАЛГААНЫ
ТОВЧ ТОЙМ**

А. Дашдэмбэрэл

Төв Азийн нүүдэлчин улс түмний дунд манж нарын түүх соёл томоохон байр эзэлдэг юм. Манж нарын гарал үүслийн талаар Хятадын болон бусад сурвалж бичигт дурдсанаар Хятадын Шань инь улс мөхөж, Чжоу улс байгуулагдах үе буюу МЭӨ 1100-аад оны үед одоогийн Хятадын зүүн хойт хэсэгт оршин сууж байсан Су шэнь нараас гаралтай гэж үзэж байна¹.

Эрдэмтдийн судлан шинжилснээр манж нарын өвөг дээдсийн анхны төр улс болох Бохай²-н үеэс манж Чин улсын мөхөх хүртэл 1000 гаруй жилийн түүхэнд Манжийн язгууртнууд газар нутгаа өргөтгөж, эд баялаг, эрх ямбаа нэмэгдүүлэхийн төлөө үргэлжийн дайн байлдаан хийж, энгийн номхон ард иргэдийн цусыг урсгаж байсан мэдээ, баримт түүх шастир, бичиг зохиолд олонтаа бичигдсэн байх юм. Энэ дайн байлдааны эцсийн зорилго нь бусад улс орныг өөрийн хараат болгож, байнга алба бариулан, эд баялагийг нь цөлмөн хоосолж, цэрэг дайны үед тогтоосон хэмжээний цэрэг, зэр зэвсгийг гаргуулж байх явдал байлаа. Монгол, Манжийн харилцааны түүх ч мөн үүнийг гэрчилж байна. Монголд Манж нарын түүх соёлыг хэдий үеэс судалж байсныг архивийн материал, түүхийн сурвалж бичиг зохиолуудад тулгуурлан нэгтгэж, товч тоймыг гаргах зорилго тавьж байна. Марксист ленинист түүхийн шинжлэх ухаан аливаа ард түмний тодорхой түүхийг ерөнхий онолын зүй тогтлын үүднээс судлахын зэрэгцээгээр бас тухайн орны нийгмийн аль нэг байгууллын хөгжилд тохиолдож байсан түүхэн үйл явдал, үзэгдлийн онцлогийг илрүүлдэг.

Монголд Манжийн түүх, соёлыг судалж байсныг түүхийн сурвалж материалаас шүүрдэн авч үзвэл: XIV зуунаас 1921 оны ардын хувьсгал, 1921 оноос хойших үе гэж хоёр үе шат болгон үечилж байна.

Монголын хамгийн сүүлчийн хаан Тогоонтөмөр 1343 онд зарлиг буулгаж, Ляо Цзинь, Сүн гурван төрийн түүх зохиох нөр их ажлын ерөнхий редактороор эрдэмтэн тогтохыг тохоон томилжээ. Тогтох уул ажлыг зарлигийн ёсоор хугацаанд нь хийж дуусгасан байна. Тогтох ба Мэргэд аймгийн Бухулай жанжны удмын Мазартайн хүү монгол хүн байжээ. Тухайн үеийн Монголын сурвалжтаны дотроос хамгийн олон боть ном уншиж зохиосон эрдэм номд төгс боловсорсон хүн

1 Алтан улсын судар. 1 дэвтэр, гар бичмэл. Пян Бо Манж үндэстэн. Бээжин 1985. 10-р-тал

2 Мөн тэнд

байв.³ Үүнээс өмнө эрдэмтэн Цагааны «Өгөдэй хаан Алтан улсыг тэгшитгэсэн эх адгийн бичиг» гэдэг монгол зохиол байсан боловч одоо хүртэл олдож судлагдаагүй байна⁴. Мөн бичиг, цэргийн нэрт түшмэл Баян «Алтан улсын түүх»-ийг засварлан гүйцээж бичсэн гэсэн мэдээ буй. Эдгээрээс өөр Манжийн түүх соёлд холбогдох сурвалж, зохиолууд байсан ч байж болзошгүй.

Юань улсын ноёрхол Хятадад унах үед «Татар хүнийг үзэгдсэн газарт нь ал. Татар үсэгтэй номыг тааралдсан газарт шатаа» гэсэн харгис уриалга бүх Хятад даяар гарч, монгол ном, судрыг удаа дараа шатаан устгаж байсан мэдээ сурвалж бичигт олонтаа тааралдана. Эдгээр мэдээ баримтаас үзэхэд монгол түүхчид Манжийн түүхийг XV зууны үеэс бичиж байжээ. Өөрөөр хэлбэл Монголд манжийн судлал XIV зууны үед үүссэн гэх үндэстэй юм.

Монголд XIII зууны үеэс эхлэн хятад, перс, түвд, манж хэлнээс ном судар орчуулж эхэлсэн байна. XII зуунаас 1921 он хүртэл зөвхөн хятад, манж хэлнээс орчуулсан уран зохиолын ном зохиол 28-29 нэр төрлийн 700-аад боть ном буюу 100 мянга гаруй тал хуудас болж байна.⁵

Манж Чин улсын үед Монголын түүхчид Монголын хаадын түүхийг зохиохдоо манжийн зарим сурвалж бичгүүдийг ашиглаж байснаас үзэхэд тухайн үед манжийн сурвалж бичгүүдийг судлан зохиол бүтээлдээ хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байжээ.

Чин улсын үед монгол түүхчид Монголын эх түүхийг манжаар зохион бичиж байсан юм. Харчины захирагч Ломи «Монгол Боржигид овгийн түүх», Баргын Далангууд овгийн Гүвэрэй «Монголын уг эх» хэмээх зохиолуудыг манжаар бичсэн байна. Энэ үед зохиогдсон манж сурвалж бичиг, хуулиудыг манж, хятад, монгол гурван хэлээр барлан хэвлүүлж тарааж байв. Мөн манж-монгол толь бичиг, сурах бичгүүд олноор зохиогдож байсан боловч манж-хятад болон гурав, таван хэлний толийг зохиосон хүмүүсийн нэрийг бичсэн атлаа манж-Монгол, монгол-манж толь бичиг, сурах бичгүүдийг зохиосон хүний нэр, оныг дурдаагүй байна. Энэ үед мөн манжийн сурвалж бичгийг орчуулах ажил хийгдэж байв. 1904 онд Богд хааны зарлигаар «Энх амгалан хааны бодлогын бичиг» хэмээх олон боть зохиолыг хүрээний бичээч, манжич Агваан, Лувсанням, Мөрдэндэв, Их шавийн зайсан Лувсанцэрэн, Балданцэрэн, Буян-Аривжих, Цогбадрах, Цэдэвсүрэн нар монголчилжээ.

Монгол улс нь Манж Чин улсын 200 гаруй жилийн дарлалаас чөлөөлөгдсөний дараа Богд хаант Монгол улсын үед Монголын төрийн эх түүх зохиох ажил эрчимжиж, энэ ажлыг дагнан гүйцэтгэх байгууллагыг байгуулан ажиллуулж байв. 1918—1919 онд Монголын засгийн газраас зориуд эрхлэн «Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир» хэмээх 11 дэвтэр улсын албан түүх зохиолгожээ. Энд Монголд Манж хааны явуулсан бодлогыг нэлээд шүүмжлэн бичсэн нь: «Манж хааны эрх баригчид шашин төрийн ёс журам цааз хуулийг хүндтэй дагаж явахыг эзэрхэгээр огоорч, хэрэг тутам хөдлөх бүр эд юм хахуулдан авах, ашгийг хичээснээс зөв хэргийг буруу, буруу хэргийг зөвд үзэж, үнэхээр цааз, сахилгыг нэгмөсөн алдагдахуйд хүрч, тэр энэ хэмээн

3 Юань ши, 1958. Шанхай, 2-р боть. 1589-р, ДДСА, 1986. № 2. 63р тал

4 Ч. Далай. Юань гүрний үеийн монгол, УБ, 1980, 10-р тал

5 ШУХ-ийн бүтээл (нийгмийн ухааны анги) 1957, № 2. 78-р тал

ялгах явдалгүй цөм бие хөрөнгө тэсвэрлэн чадахгүй болсонд арга буюу Богд Жавзандамбыг Монгол улсын шашин төрийг хослон баригч хагаан болгов⁶ хэмээжээ.

Иш татсан зүйлд хэдийгээр харийн дарлагчдын бодлогыг дотоодын ноёлогч феодал ангийнхны үзэл санааны үүднээс явцуухан шүүмжилж, тусгаар төр улс байгуулах болсны шалтгааныг өнгөцхөн тайлбарласан боловч тэр үеийн Монголын түүх бичлэгт манжийн төрийн бодлогыг дүгнэн шинжлэх оролдлого хийж байсныг тэмдэглүүштэй. Энэ үед засгийн газраас манж хэлтэй хүмүүсийг бэлтгэх явдалд ихээхэн анхаарч, Нийслэл хүрээ, Ховд, Улиастай зэрэг газруудад бага, дунд сургуулиудыг байгуулах, дунд сургуульд үзэх хичээлийн программд манж хэлийг үзэхээр оруулсан байна.

Тус оронд Ардын хувьсгал ялж, шинэ үеийн шинжлэх ухааны анхны байгууллага Судар бичгийн хүрээлэнг байгуулсан нь улс орны соёл, шинжлэх ухааны хөгжилд шинэ үе шат болсон юм. Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан үеэсээ эхлэн түүхийн холбогдолтой ном, судрыг олж цуглуулах, гадаад хэл дээрх чухал номыг орчуулах ажлыг эрхлэн, шуурхай гүйцэтгэж эхэлсэн юм. Судар бичгийн хүрээлэнгийн хүмүүсийг өөрийн орны доторх аймаг, хошуудад болон Бээжин, Хөх хот зэрэг газруудаар ном судар цуглуулах ажлаар улсын зардлаар урт богино хугацаагаар томилон явуулж байлаа. Хүрээлэнд цуглуулсан гадаад хэлний ном зохиолыг эмхлэн цэгцлэх, данслан бүртгэх ажил 1920-иод оны сүүлчээс эхэлсэн байна. 1929 онд гаргасан манж номын бүртгэл улсын архивт байна. Манж үсгийн номыг тусад нь эмхлэн цэгцлэхийн тулд манж номын гарчиглагчаар түр хугацаагаар хүн авч ажиллуулж байв.⁷

Эдүгээ УННС-ийн манж номын хөмрөгт манж үсгийн 140 гаруй нэр төрлийн 4000 гаруй боть түүх, уран зохиол, толь бичиг, сурах бичиг, хууль цаазын холбогдолтой ном зохиол хадгалагдаж байна.

Монгол улсын судар түүхийг хятад хэл ба манж, төвд, франц, англи, оросоос орчуулсан нь бүгд 100 гаруй дэвтэр болов, гэж Судар бичгийн хүрээлэнгийн 1924 оны тайланд тэмдэглэжээ. 1920—30-аад оны хооронд «Дайляо улсын судар», «Алтан улсын судар», «Дайчин гүрний тулгуур төр нээсэн бодлогын бичиг», «Зүүн гарын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг», «Тунжиян ганму бичиг зэрэг олон сурвалж бичгүүдийг орчуулсан байна. Манж үсгийн судар түүхийг орчуулах ажилд Шинжлэх ухааны хүрээлэнгийн анхны гишүүн Ч. Бат-Очир (1873—1935) Б. Буянчуулган (1885—1937), Л. Дэндэв, (1895-1957) нар ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Тухайн үед манжаас монгол хэлнээ орчуулах ажил өрнөж байсан учраас хүрээнд суугаа манж хэл мэдэх хүмүүс орчуулга хийхийг хүссэн өргөдлийг Судар бичгийн хүрээлэнд ирүүлж байжээ

Судар бичгийн хүрээлэнгээс тэр үед онц шаардлагатай байгаа зарим зохиолуудыг манж хэлнээс орчуулах ажлыг хүмүүстэй гэрээ байгуулан хөлсийг өгч, орчуулуулж байв. Тухайлбал 1930 оны 6 сард Дөрвөн Ойрад болон Монголын түүхэнд чухал холбогдол бүхий «Зүүн гарын бичгийг» яаралтай орчуулах шаардлагатай тул өвчний учир бүрмөсөн чөлөө авч, хөдөө нутагт биеэ сувилуулахаар явах манжич Ч. Бат-Очирын хүсэлтийг ёсоор болгохын хамт уг зохиолын 4 дугтуй

6 Монгол улсын шастир II дэвтэр.

7 УТТА Ф23—2—51

8 УТТА Ф 23—1—258 ШУА-ийн фонд.

32 дэвтрийг орчуулуулахаар 160 төгрөгийн урьдчилгаа хөлс олгосон гэрээ, баримт түүхийн төв архивт байна.⁹ Манжич Ч. Бат-Очир Судар бичгийн хүрээлэн байгуулагдахад анхны гишүүнээр орж, арваад жил ажиллахдаа манж, монгол түүхийн ном, сурвалж бичиг цуглуулах, манж үсгийн ном зохиолыг орчуулах, номын санд цуглуулсан манж үсгийн ном, судрыг бүртгэж, эмхлэн цэгцлэх ажлыг хийж, зохион байгуулахын зэрэгцээгээр түүхийн сурвалж бичгийг судлах, Монголын эх түүхийг зохиох ажилд оролцож байсан манай ахмад түүхчдийн нэг билээ. Тэрээр 1922 онд «Тун жиян ганму бичиг»-ийн 95 дэвтэр, «Нэвтэрхий толь»-ийн 85 дэвтрийг Судар бичгийн хүрээлэнд олж авчирчээ.

1932 оноос Шинжлэх ухааны хүрээлэнд ажиллаж байсан Л. Дэндэв, Б. Буянчуулган нар манжийн судлалд зохих хувь нэмрээ оруулжээ. 1930-аад оны үед манж хэлнээс ном зохиолыг орчуулахын зэрэгцээ орчуулсан болон манж хэл дээрх материалыг ашиглан, манжийн үеийн Монголын түүхэнд холбогдох судалгааны зохиолуудыг бичиж байв. Түүхч Б. Буянчуулган Манж Чин улсын дунд сургуулийг төгссөн нэрт манжич Судар бичгийн хүрээлэнгийн түүхийн тасгийн судлаач, эрхлэгчийн ажлыг хийж байх үедээ манж хэл дээрх Монголын түүхэнд холбогдох ном зохиолуудыг орчуулахаас гадна манж, хятад материалд тулгуурлан «Манжаас Монголыг эзэрхсэн үеийн хэрэглэгдэхүүн» (УБ. 1936), «Монгол Өөлдийн түүх» (1936, 1937) «Манж Монголын холбогдсон түүхт байдал» (гар бичмэл) зэрэг хэд хэдэн түүх судалгааны ном, өгүүлэл бичсэн байна.

1940-өөд оны үеэс манжийн судлалыг эрхлэн гүйцэтгэж явуулах мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудалд анхаарал тавьж эхэлжээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны 1945 оны тогтоолоор МУИС-д Хэл бичгийн факультет нээж, монгол хэл, түүхийн салбарын оюутнуудын үзэх хичээлийн программд манж хэлийг оруулсан байна. Түүнчлэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны 1956 оны тогтоолоор Хэл бичгийн факультетэд гадаад хэлний салбарыг буй болгон 1957 оны хичээлийн жилээс эхлэн манж хэлний анги шинээр нээж, 1962, 1963 онд 2 удаа манжийн судлагчдыг төгсгөн гаргасан билээ. Манж хэлний мэдлэгтэй судлаач, боловсон хүчнийг бэлтгэхэд ахмад түүхч, манжич Л. Дэндэв чухал хувь нэмэр оруулсан юм. Тэрээр оюутнуудад зааж байсан хичээлүүдээ цэгцлэн нэгтгэж, суралцахад хялбар дөхөм болгож, оюутнуудад ойлгомжтой нэр томъёогоор баяжуулан манж хэлний сурах бичгийг 1947 онд зохион хэвлүүлсэн. Энэ ном олдохгүй нэгэнт ховордсон тул түүний шавь эрдэмтэн Л. Мишиг уг сурах бичигт бараг засвар өөрчлөлт оруулалгүй, хойно нь шинэ үгийн толь хийж хавсарган, оршил бичиж дахин хэвлүүлэн гаргажээ. Энэхүү сурах бичиг нь одоо хүртэл манж хэлийг сурах оюутнуудын гарын авлага болон хэрэглэгдсээр байна. Эрдэмтэн Л. Мишиг 1959 онд УННС-ийн манж номын хөмрөгт байгаа бүх манж номын гарчгийг ном зүйн зарчмыг баримтлан хэвлэгдсэн оны дараалалын дагуу нэгтгэж, товч тайлбартайгаар хэвлүүлж гаргасан нь түүхч судлаачдын олж ашиглахад хялбар дөхөм болгосон байна.

1940—50-иад оны үед манж үсгийн ном орчуулах ажил хийгдэж байв. Манжич Л. Дэндэв хаадын «богд сургаалууд» болон хууль зүйлийн бичгүүдээс Монголын түүхэнд холбогдох хэсгийг цөмж түүвэрлэн

орчуулж, «Манжаас Монголыг колоничилсон үеийн түүхт хэрэглэгдэхүүн» хэмээх томхон хураамж бичиж үлдээсэн нь одоо гар бичмэлээр хадгалагдан буй. Мөн шавь нарын хамт манжийн гарал үүсэл, түүхэнд чухал холбогдолтой «Нэвтэрхий толь» хэмээх зохиолын 80 дэвтрийг орчуулсан байна. Манжич Ж. Дамдиндорж 1960-аад оны эхээр манжийн «Үнэн магад хуул»-ийг орчуулсан нь манжийн түүх соёлыг судлахад үнэтэй хэрэглэгдэхүүн болж байна.

1920-иод оны сүүлчээс 1930-аад оны дунд үе хүртэл манай түүхчид зөвхөн манж үсгийн ном зохиолыг цуглуулах, эмхлэн цэгцлэх, монгол хэл дээр орчуулах чиглэлээр ажиллаж байсан бол 1930-аад оны сүүлчээс цуглуулсан материалд тулгуурлан манж монголын түүхэнд холбогдох судалгааны ном, өгүүлэл бичиж, нийтлүүлж эхэлсэн байна. Энэ үеийн түүхчид, судлаачид орчуулсан үнэ цэнтэй сурвалж, зохиолуудаас зөвхөн монголын түүхэнд холбогдох хэсгийг нь тусгайлан нэгтгэн боловсруулж хураамжлахыг чухалчлан үзэж байв. Энэ зорилгоор хийгдсэн бүтээлүүд нь одоо ч чухал хэрэглэгдэхүүн болсоор байна.

Монголын түүхчид 1960-аад оноос дундад зууны үеийн арвин их материалд тулгуурлан манжийн үеийн Монголын түүхийг тал бүрээс нь нарийвчлан судалсан эрдэм шинжилгээний томоохон бүтээлүүд олноор бичсэн байна. Үүнд, түүхч Ш. Нацагдорж, Д. Гонгор, Н. Ишжамц, Ц. Насанбалжир, Ц. Содномдагва, Л. Санждорж нарын бүтээлүүдийг нэрлэж болно.

Академич Ш. Нацагдорж¹⁰ архивийн арвин материал, бичмэл сурвалж бичиг олныг иш үндэс болгож, Манжийн үеийн халхын түүхийг хураангуйлан нэгтгэж, гаргахдаа Манжийн төрөөс Монголын ард олныг боолчлон мөлжиж байсан мөлжлөгийн хэлбэр, манж төрийн бодлого, засаг захиргаа, хууль цаазын харгис чанарыг задлан шинжилсэн манжийн ноёрхлын үеийн томоохон зохиолыг туурвисан юм.

Түүхч Ц. Насанбалжир¹¹ Манжийн ба бусад сурвалж бичгийг ашиглан Манжийн төрийн цэрэг, түшмэдийн засаг захиргааны Монгол дахь систем болон Ар монголоос Манжид залгуулж байсан бие ба эд хөрөнгийн олон янзын алба, албаны өрийн системийг судалсан байна.

ШУА-ийн сурвалжлагч гишүүн Н. Ишжамц¹² Манжийг эсэргүүцсэн Амарсанаа, Чингүнжав нарын удирдлагын дор Монголын ард түмний зэвсэглэн боссон түүхийг судалж бичихдээ: Манжийн хаад ноёд, түшмэдийн цэрэг дайны бослого, Монголын ард түмний тусгаар тогтнолыг даран устгахын төлөө хүч, хөрөнгө хайрлахгүй улайран зүтгэж байсныг тодорхой харуулсан юм.

Л. Санждорж, Ц. Содномдагва нарын түүхчид Манжийн дарлал, Хятадын худалдаа, мөнгө хүүлийн капитал Монголд нэвтэрсэн түүх, Монгол дахь Манжийн засаг захиргааны зохион байгуулалтыг тусгайлан авч, судлан шинжилж нэгэн сэдэвт зохиолууд бичсэн байна.

Манай түүхчдийн Манжийн үеийн Монголын түүхийн талаар гарсан нэгэн сэдэвт томоохон бүтээлүүд нь тухайн үеийн Монголын түүхийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан чухал хэрэглэгдэхүүн болж байна. Манж Чин улсын үеийн улс төр, эдийн засгийн бодлого,

10 Ш. Нацагдорж. Манжийн үеийн Халхын хураангуй түүх. УБ. 1963.

11 Ц. Насанбалжир. Манж Чин улсад Ар монголоос нийлүүлж байсан алба, УБ. 1963.

12 Н. Ишжамц. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын тэмцэл. УБ. 1962.

төр, цэрэг, хууль цааз, засаг захиргааны зохион байгуулалт, системийг гүнзгий судалж, энэхүү бүтээлүүдийг туурвиснаараа манжийн судлалд холбогдох юм.

БНМАУ-ын түүхийн гуравдахь удаагаа нэмэн засварлаж хэвлэсэн нэгэн ботид: «XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүхээр бичсэн Монголын эрдэмтдийн бүтээл нь Манжийн дарлал Монголд «хамгийн хүнд бэрх зовлон зүдгүүрийн үе байсан бөгөөд Монголын ард түмэн Манжийн боолчлолыг түлхэн унагахгүйгээр ... олон зуун жилийн хоцрогдлыг даван туулж, хөгжил дэвшлийн замд орж чадахгүй байсан» гэдгийг нотлон харуулжээ. Чин улсын түрэмгийлэн колоничлох бодлого нь Хятадын шунахай худалдаа мөнгө хүүлэл, гадаадын капитал ба мөлжигчдийн хүнд хэцүү дарлалтай нийлж тус орны үйлдвэрлэлийн харилцааны бүхий л системийг гүнзгий хямралд оруулж, ард түмнийг үгүйрүүлэн XX зууны эхээр тус орныг үндэс угсаагаараа балран мөхөхийн даваан дээр хүргэж, ийнхүү Манжийн дарлал нь Монголд цаглашгүй их гаслан зовлон учруулсныг Монголын түүхчид тод үзүүлсэн байна.

Хөрөнгөтний түүхийг гуйвуулагчдаас Манжийн ноёрхолыг цагаатган тэр үед Монголын ард түмэн ямар ч зовлон зүдгүүргүй, жаргалтай байсан мэтээр үзэж байгаад зохих хариулт болж Монголын эсрэг их гүрний дээрэнгүй туйлын буурангуй бодлого явуулж байсан манж Чин улсын боолчлогчдод нь Монголын ард түмний заналт дайсан мөн болохыг илрүүлэн заасан юм. . .» гэж Монголын түүхчдийн бүтээлийн ач холбогдлыг өндрөөр үнэлэн бичсэн байна.¹³

1960-аад оноос Монголд манж хэлний судлал эрчимтэй хөгжиж ирэв. Манж хэл судлагчид манж хэлний гарал үүсэл, үгзүй, манж монгол хэлний дагавар, нөхцлийн ойролцоо ба ялгаатай талуудыг харьцуулан судалж байна. МУИС-ийн багш Чой. Лувсанжав, Цэ. Шархүү нар урьд өмнө гарсан олон хэлний толь бичгүүдийг ашиглан 22 мянга гаруй үгтэй Манж-монгол хэлний толь бичгийг зохиож, 1968 онд хэвлүүлсэн байна.

Манж хэлний судлаач агсан Го. Мижиддорж манж хэлний судлалын талаар олон жил дагнан оролдож, нэлээд зүйл хийжээ. Тэрээр манж монгол хэлний дагавруудыг харьцуулан судалж, олон өгүүлэл бичсэн ба түүнийгээ цаашид гүнзгийрүүлэн «Манж - Монгол хэлний харьцуулсан зүй гэдэг эрдэм шинжилгээний томоохон хэмжээний ганц сэдэвт бүтээл туурвисан байна.

1980-аад оноос түүхч, судлаачид манжийн үеийн Монголын түүхэнд холбогдох сурвалж зохиолуудыг судлахын хамт манжийн түүх соёлын талаар тусгайлан судалгаа хийж, манж үндэстний гарал үүсэл, аж ахуй, зан заншлын талаар судалгааны өгүүллүүд бичиж байна.

Манж үндэстний түүх, соёл болон манжийн үеийн сурвалж бичиг, материалыг шинжлэн судлах нь зөвхөн манж үндэстний түүхийг мэдээд зогсохгүй, Монголын болон төв Азийн нүүдэлчдийн түүх соёлыг судлахад чухал ач холбогдолтой юм.